Монгол улсын Засгийн Газар Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран Анод банкныг үндэсний эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдлыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг нь үнэлэн *"Монголын Шилдэг Банк"*-аар өргөмжлөв.



Монголын Хөрөнгийн Бирж Анод банкныг Монгол улсын үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь бий болгох, хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсныг үнэлж, оны *"Шилдэг Хөрөнгө Оруулагч Банк"*-аар шалгарууллаа.



Анод банкны Гүйцэтгэх захирал Д.Энхтөр Монголын Социалист Ардчилсан Залуучуудын Холбооны (МСАЗХ) *"Алтан Од"* медалиар шагнууллаа.

Банкны Маркетингийн газрын захирал О.Эрдэнэбулган 2004 оны Монгол Улсын *"Шилдэг Маркетер"* боллоо.

БАНКНЫ ТУХАЙ

Валют арилжаагаар анх 1992 онд бизнесийн гараагаа эхэлсэн Анод ХХК нь богинохон хугацаанд төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк бус санхүүгийн байгууллага болж, үйл ажиллагаагаа өргөтгөсөн юм. Таван жилийн турш банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж байгаад улмаар 1999 оны 8 дугаар сард Монгол Банкны Ерөнхийлөгчийн 164 тоот тушаалаар арилжааны банк байгуулах албан ёсны зөвшөөрөл авсан билээ. Тэр цагаас хойш Анод банк нь иргэдийн болон байгууллагын банк, худалдааны санхүүжилтийн салбарт ноёрхож, зах зээлийнхээ байр суурийг өргөжүүлсээр ирсэн юм. Анод банк нь банк санхүүгийн салбарт үргэлж шинийг санаачлагч байдгаараа нэр хүндтэй. 2001 онд анхны Цахим төгрөг дотоодын төлбөрийн картыг үйлчилгээнд нэвтрүүлж байлаа. Түүнчлэн 2004 оноос андеррайтерын үйл ажиллагааг эрхэлж эхэлснээр Анод банк ийм төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг Монголын хамгийн анхны банк болсон билээ.

Анод банк Улаанбаатар хот болон найман аймагт байрлах тооцооны төвүүдээрээ дамжуулан санхүүгийн цогц үйлчилгээг ард түмэндээ үзүүлж байдаг. Анод банкны нийт активын хэмжээ 2004 онд 133.9 тэрбум төгрөгт хүрсэн нь Монгол улсын банкны системийн нийт активын 12.1 орчим хувийг эзэлж байна. Анод банк эрсдийн удирдлага болон хүний нөөцийг сайжруулах тал дээр олон арга хэмжээ авсаар байна. Банк 450 гаруй ажиллагсадтай. Түүнчлэн 2004 онд дэлхийд нэр хүндтэй 13 банкуудтай корреспондент харилцаагаа өргөжүүллээ. Анод банк өөрийн чадварын цар хүрээ, шинэ санаачлага, харилцагчаа дээдэлсэн үйлчилгээгээрээ Монгол улсын тэргүүлэгч банкуудын нэг юм.

2004 онд хийсэн бүтцийн өөрчлөлтөөр Анод банк харилцагчийн үйлчилгээний 6 газартай болсон: Том Харилцагчийн банкны газар, Байгууллагын банкны газар, Иргэдийн банкны газар, Гадаад Харилцааны газар, Хөрөнгө Оруулалтын банкны газар болон Картын Үйлчилгээний газар. Харилцагчдад чиглэсэн бүтэц, чанарыг эрхэмлэсэн байдал нь банкны үйл ажиллагааг улам тодорхой болгож байна.

Удирдлагын Баг



ОЮУНСҮРЭН
Эрэгзэн

МӨНХБАТ
Рэнцэнханд

АЧИТ-ЭРДЭНЭ
Дарамбазар

ДАРЬБАЗАР
Дандгай

ЦЭЦЭГМАА
Батсуурь

УЛАМБАЯР
Лхамсүрэн

ГАНБАЯР
Батбазар

Том
Харилцагчийн
банкны газрын
Захирал

Хууль, Эрхзүйн
газрын Захирал

Хөрөнгө
Оруулалтын
Банкны газрын
Захирал

Байгууллагын
Банкны газрын
Захирал

Иргэдийн
Банкны газрын
Захирал

Гадаад
Харилцааны
газрын Захирал

Зээлийн
газрын
Захирал

Стратеги
Төлөвлөлтийн
газрын Захирал



ЭРДЭНЭБУЛГАН
Оюун

АРИУНАА
Дэмбэрэл

САРУУЛ
Чимэддорж

БАТХУЯГ
Найгал

ЭНХЦЭЦЭГ
Гомбожав

БОЛОРМАА
Сампилноров

Маркетингийн
газрын Захирал

Санхүүгийн
Удирдлагын
газрын Захирал

Ерөнхий
Зохицуулалтын
газрын Захирал

Мэдээллийн
Технологийн
газрын Захирал

Ерөнхий Нягтлан
Бодогч

Дотоод Хяналтын
газрын Захирал

Хүний Нөөцийн
газрын Захирал

БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ГАЗАР

Анод банкны Байгууллагын Банкны Газар нь Зээлийн болон Бүртгэл Тооцооны хоёр үндсэн албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. 2004 оны эцсийн байдлаар нийт 23 ажиллагсадтайгаар, хоёр алба, нэг салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын банкны газар нь Анод банкны нийт гүйлгээний 35-40 хувь, харилцах болон хадгаламжийн 80 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 21 хувийг тус тус эзэлж, 3000 гаруй харилцагчид үйлчилдэг.

ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ТҮҮНИЙ ХАНДЛАГА

Ирээдүйд Байгууллагын банкны газар нь зах зээлийнхээ дунджаас дээгүүр хувийг эзэлж, тухайн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг байгууллагуудад банкны чанартай үйлчилгээ хүргэх замаар тэдэнтэй хамтарч ажиллах тогтвортой стратеги, үйл ажиллагааг баримтлах болно. 2005 онд Байгууллагын банкны газар нь үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, зах зээлийн томоохон, идэвхтэй төлөөлөгчдийг татах зорилттойгоор ажиллана.

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бид өнгөрсөн онд улс орны эдийн засгийн гол гол салбаруудад 23.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 24.5 тэрбум төгрөгийн зээл төлүүлж санхүүгийн зуучлалын үүргээ амжилттай биелүүллээ. Ингэснээр зөвхөн манай газар нь 5.3 тэрбум төгрөгийн татварын өмнөх орлогыг банкиндаа оруулсан байна.


Байгууллагын банкны газар зээлийн багцынхаа 58.0%-ийг аж үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга болон электрониксийн барааны засвар, үйлчилгээний салбаруудад, 8.1%-ийг уул уурхайн салбарт олгосон нь бидний Монгол улсынхаа хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг тодорхой харуулж байна. Бид барилгын салбарын томоохон төлөөлөгчид болох Мон-Элдорадо ХХК, Зарубежстрой ХХК, Богда Холдинг, Авзага Трейд ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаж байгаадаа баяртай байдаг.

ЦААШИД БАРИМТЛАХ БОДЛОГУУД


Банкны уян хатан бодлогод нийцүүлэн бид банкныхаа зээлийн үйлчилгээг өргөжүүлээд зогсохгүй санхүүгийн зөвлөгөө үзүүлэх замаар зээлийн үр ашиг, зөв зүйтэй хэрэглээг баталгуужуулах зорилттойгоор ажиллах болно.

Бид хөрөнгө оруулалтын санхүүжилтын тал дээр ялангуяа оновчтой зээлийн бүтээгдэхүүнүүдийг сонгох асуудал дээр харилцагчидтайгаа нягт уялдаа холбоотой ажиллана.

НИЙТ ЗЭЭЛ




НИЙТ ХАДГАЛАМЖ



ТОМ ХАРИЛЦАГЧИЙН БАНКНЫ ГАЗАР

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДААР ЗЭЭЛЖҮҮЛЭЛТ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Том харилцагчийн банкны газар нь Монгол улсын томоохон шилдэг компаниудад санхүүгийн үйлчилгээг тэдэнтэй харилцан ашигтай, нягт хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар тусгайлан чанарын өндөр түвшинд үзүүлдэг. Бүс нутгийнхаа шилдэг үр ашигтай, өрсөлдөхүйц банк болох банкныхаа хэтийн зорилгод хувь нэмрээ оруулж, банкны ашигт ажиллагааг хангахыг зорьж байдаг.

Манай газар нь Зээлийн болон Харилцагчийн Үйлчилгээний албатайгаар, 19 чадварлаг ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Анод банкны нийт гүйлгээний 25 хувь, харилцахын үлдэгдлийн 15 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 54 хувийг манай банкны газар эзэлж, харилцагч нартаа үйлчилдэг.

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2004 онд бид улс орны эдийн засгийн гол гол салбаруудад 34.6 тэрбум төгрөгийн зээл олгож, 29 тэрбум төгрөгийн зээлийг төлүүллээ. Нийт 11.2 тэрбум төгрөгийн татварын өмнөх орлогыг банкиндаа оруулав.

Бид нийт олгосон зээлийнхээ 34.5 хувийг өнгөрөгч оны Монгол улсын эдийн засгийн 10.6 хувийн өсөлтөд голлох хувь нэмэр оруулсан уул уурхайн салбарт олголоо. Бид уул уурхайн салбарын томоохон төлөөлөгчид болох Алтан Дорнод Монгол ХХК, Монгол Газар ХХК, Гацуурт ХХК, Эрдэс Холдинг ХХК зэрэг компаниудтай хамтран ажилладаг. Түүнчлэн Монгол Газар компанийн Өмнөговь аймаг дахь Олон Овоотын алтны үндсэн орд газарт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд тус орд газар нь олон улсын стандарт хэмжлээр 18.5 тоннын нөөцтэй манай улсын үндэсний томоохон баялаг билээ.

МАНАЙ ШИЛДЭГ ХАРИЛЦАГЧ



Анод банк нь бидэнд бизнесээ эрхлэхэд сайн нөхөр болж чаддаг. Тэд үргэлж шинийг санаачилж, бас урам зориг өгч байдаг билээ.

Сергей Викторович ПАУШОК

"АЛТАН ДОРНОД - МОНГОЛ" ХХК -НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ИРГЭДИЙН БАНКНЫ ГАЗАР

2004 оны санхүүгийн жилд, Иргэдийн банкны газар нь зах зээлийн байр сууриа бэхжүүлэх, харилцагч нарт чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зорилттойгоор ажиллалаа. Үүний үр дүнд 200 гаруй ажиллагсадтай Улаанбаатар, Ховд, Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад байрлах 21 салбар, тооцооны төвүүдээрээ дамжуулан иргэддээ иргэдийн банкны цогц үйлчилгээг хүргэж байна.

2004 оны эцсийн байдлаар, тус газар нь Анод банкны хэмжээнд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 85 хувийг бүрдүүлэв. Тайлант онд иргэдийн 9803 зээлийн өргөдлийг хүлээн авч, 38.6 тэрбум төгрөгийн зээлийг 8255 иргэдэд олгосон бөгөөд 4685 зээлдэгчийн 26.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Зээлийн өрийн үлдэгдэл 25.2 тэрбум төгрөгт хүрчээ. Харин хадгаламжийн хувьд иргэдээс 73.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэв. Өмнөх онтой харьцуулахад татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 21.8 тэрбум төгрөгөөр, зээлийн хэмжээ 1.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Бид зээлээ аль хэрэгцээ, шаардлага өндөр байгаа зах зээлд хуваарилж чадсанаар манай ашигт ажиллагаа ч нэмэгдлээ. Дунд орлоготой хүн амд чиглэсэн “Анод банк ард түмний банк” сэдэвт маркетингийн компанит ажил өрнүүлснээр хоёр салбар шинээр нээгдлээ. Банкны салбар, тооцооны төвөөр дамжин хүрэх бидний үйлчилгээг сонирхох иргэдийн сонирхол, эрэлт нь их хэмжээгээр өсч байна.

Улаанбаатар хотод оршин суудаг гадаад иргэдэд банкны үйлчилгээ авахад тулгардаг хүндрэлтэй асуудлууд олон гардгийг тогтоосны үндсэн дээр тэд нарт зориулсан тусгай салбаруудыг нээв. Манай банкны тооцооны 18 дугаар төв Хятад харилцагч нарт, тооцооны 19 дүгээр төв Солонгос харилцагч нарт, тооцооны 22 дугаар төв англи хэлтэй харилцагч нарт үйлчилдэг. Энэхүү шинэлэг үйлчилгээг эрэлт өндөр байгаа бөгөөд Хятадын Хөрөнгө Оруулагчдын Холбоо, Солонгос Иргэдийн Нөхөрлөлийн Байгууллагаас өндөр үнэлж, дэмжлэг тусалцаа үзүүлсэн.

2005 онд Иргэдийн банкны газар нь иргэдэд болон мэдээлэл холбооны системд илүү түлхүү анхаарлаа хандуулна. Харилцагч нарынхаа хүсэл, сонирхлыг илүү их мэдэж авахын тулд бид зах зээлийн судалгааг хийж, мэдээллийн баазаа бүрдүүлээ. Бүрэн автоматчилагдсан банкны систем болох RS Bank 5.1-ийг банкиндаа нэвтрүүлэв. Энэ системийн хүрээнд клиент банк, телефон банк, интернет банкны үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, харилцагч нартаа хүргэлээ. Ирээдүйд ашигт ажиллагаа болон бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэхийн тулд Анод банк тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсээр байх болно.

МАНАЙ ХАРИЛЦАГЧ



Миний хувьд Анод банкны харилцагч байж, эелдэг харилцаатай ажилтнуудаар нь үйлчлүүлж байгаадаа баяртай байдаг. Анод банкнаас авч байгаа үйлчилгээ, зөвлөгөө нь бидэнд бизнесийн үйл ажиллагаа оргожүүлэхэд цргэлж дэмжлэг болж байдгийг хэлэх нь зүйтэй. Цаашид бидний харилцаа улам бүр оргожино гэдэгт итгэлтэй байна.

Хатагтай Дагвын БЯМБАСҮРЭН
“БАТ” СУПЕРМАРКЕТИЙН
ЭЗЭН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Анод банкны Хөрөнгө оруулалтын банкны газар нь 2004 оны 2 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд бидний зорилго бол Монгол улсдаа банк санхүүгийн салбарт хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг цогцоор нь нэвтрүүлэх явдал юм. Тус газар нь хөрөнгийн зах зээлийн болон төслийн санхүүжилтын гэсэн хоёр албатайгаар ажиллаж байна.

Анод банк нь Монгол улсын Үнэт цаасны хороо болон Монгол банк зөвлөлдсөний дагуу андеррайтерийн үйлчилгээ явуулах тусгай эрхийг авсан анхны банк болсон юм. Бид хөрөнгийн зах зээлд дээр андеррайтерийн үйл ажиллагааг эрхлэх ажлын хүрээнд Хөрөнгийн бирж, брокер, дилерийн компаниудтай идэвхитэйгээр нягт хамтран ажиллаж байна. Олон нийтийн дунд харьцангуй шинэ ойлголт болох бонд, бондын зах зээл, хөрөнгийн зах зээлийн талаар тайлбарлаж, мэдлэг олгохын тулд өдөр тутмын сонин хэвлэлээр цуврал хичээл явуулах, реклам сурталчилгаа явуулах, цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэн хүргэх, хэвлэлийн бага хурал хийх, сонинд хэвлэлд ярилцлага өгөх гэх мэт ажлуудыг цогцоор авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд олон нийтийн бонд, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна.

Анод банк Монголын томоохон компаниудын нэг М-Си-Эс Электроникс ХХК-ийн 2.64 тэрбум төгрөгийн бондын андеррайтераар амжилттай ажилласан юм. Ард иргэдийн эрэлтийг үндэслэн Хөрөнгө Оруулалтын банкны газраас М-Си-Эс электроникс ХХК-д бондоо ам.доллараар гаргахыг зөвлөсний дагуу 1 сая ам.долларын бондыг олон нийтэд санал болгож, арилжаанд оруулсан юм. Мөн Анод банк арилжааны банкуудаас анх удаа банкны бондыг хөрөнгийн зах зээл дээр гаргалаа.

Анод банкны хөрөнгийн зах зээл дээр явуулж байгаа үйл ажиллагааг үнэлж Монгол улсын Хөрөнгийн биржээс Анод банкыг 2004 оны "Шилдэг Хөрөнгө Оруулагч Байгууллага"-аар өргөмжилсөн.

Хөрөнгө Оруулалтын банкны газар нь мөн Монголын компаниудыг гадаадын хөрөнгө оруулалт татахад санхүүгийн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх ажлыг эхлүүлэн идэвхитэй ажиллаж байна. 2004 оны 11 дүгээр сард бид Монгол Газар ХХК-тай Олон Овоотын уурхайн хөгжил дэвшилтэнд санхүүгийн зөвлөгчөөр ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

Төслийн санхүүжилтийн хэлтэс нь 2004 онд Азийн Хөгжлийн Банкны эх үүсвэрээр хэрэгжүүлсэн "Орон сууцны санхүүжилтийн төсөл"-ийн зээл, "Ажлын байр нэмэгдүүлэх төсөл"-ийн зээл, "Ходоо аж ахуйн салбарыг хөгжүүлэх төсөл"-ийн зээл, Дэлхийн Банкны эх үүсвэрээр хэрэгжүүлсэн "Бичил санхүүгийн хөгжлийн төсөл"-ийн зээл, Нэгдсэн Үндэсний Байгууллагын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн "Дулааны хэмнэлттэй орон сууцны төсөл"-ийн зээлүүдийг дамжуулан зээлдэх банкаар шалгарахад бизнес төлөвлөгөө бичиж, банкаа хэлэлцээрт төлөөлөн оролцож гол үүрэг гүйцэтгэсэн. Иргэдийн банкны газартай хамтран ажилласны үр дүнд дээрх төслийн зээлийн эх үүсвэрээс 4.9 тэрбум төгрөгийг татан иргэд байгуулагад дамжуулан зээлдүүлсэн. Түүнчлэн "Орон сууцны санхүүжилтийн төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлсэн гэж Азийн хөгжлийн банкны зөвлөхийн зүгээс дүгнэсэн билээ.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Анод Банк нь 2000 онд Монгол Банкнаас гадаад төлбөр, тооцооны үйл ажиллагаа явуулах эрх, 2004 онд үнэт металлын үйл ажиллагаа явуулах эрхийг авсан билээ. Бид харилцагчиддаа гадаад валютын арилжаа, баримтат тооцоо, гадаад гуйвуулга шилжүүлэг, замын чек, үнэт металлын үйл ажиллагаа зэрэг цогц үйлчилгээг үзүүлж байна.

Анод Банк дэлхийн нэгдүгээр зэрэглэлийн олон банкуудтай харилцаатай ажилладаг. Бид Дрезднер банк, ЭйчЭсБиСи, Юнион Банк оф Калифорния болон бусад олон банкинд ностро дансаа нээж, төлбөр тооцоо гүйцэтгэж байна. Харилцагчиддаа илүү өргөн боломжтой үйлчилгээ үзүүлэх үүднээс Анод Банк олон улсын СВИФТ болон Ройтерсийн сүлжээнд гишүүнээр элссэн билээ.

2004 онд Анод Банкны гадаад валютын арилжаа, үйлчилгээний шимтгэлийн орлого 2003 онтой харьцуулахад 6 дахин өсч, 833 сая төгрөгт хүрсэн байна.

ШИНЭ КОРРЕСПОНДЕНТ БАНКУУД (2004)


1. ТуранАлем банк, Алма-Ата, Казакстан
2. Кореан Эксченж банк, Сөүл, Солонгос
3. Фориен Трейд банк, Москва, ОХУ
4. Сумитомо Мицуби банк, Токио, Япон
5. Хятадын Констракшн банк, Эрээн хот, БНХАУ
6. Баерише Хайпо-Унд Верайнсбанк, Австри, Герман
7. ЭйчЭсБиСи банк, Лондон, Англи
8. Кредит Суиссе, Цурих, Швейцарь

МАНАЙ ШИЛДЭГ ХАРИЛЦАГЧ



Манай компанид санхүүгийн хэрэгцээ гарсан үед бид Анод банкинд ханддаг. Тус банкны ажиллагсад нь маш найрсаг, шуурхай үйлчилдэгт нь талархаж явдаг юм. Анод банкны шинэ зээлийн болон бондын андеррайтерийн үйлчилгээнүүд нь компаниудад санхүүгийн нэмэлт боломжийг бий болгож буй учир бид талархан хүлээж авч байна.

Хятагтай Готовын АЛТАН
"АЛТЖИН" ХХК -НИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



АНОД БАНК

2004 ОНЫ ШИЛДЭГ БАНК



Санхүүгийн Хэсэг



P.O. Box 10047
50702 Kuala Lumpur
Malaysia

Tel: + 60 (3) 2095 3388
Fax: + 60 (3) 2095 0971
E-mail: info@kpmg.com.my

<http://www.kpmg.com.my>

АНОД БАНКНЫ ГИШҮҮДЭД ХҮРГЭХ АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид 4-өөс 28-р хуудсанд нийтлэгдсэний дагуу Анод банкны санхүүгийн тайланд аудит хийлээ. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл эдгээр санхүүгийн тайланг бэлтгэн тайлагнах үүрэгтэй.

Бидний үүрэг бол аудит хийж санхүүгийн тайланд хараат бус аудиторын дүгнэлт өгөх явдал бөгөөд дүгнэлтээ Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнах үүрэгтэй. Бид энэ тайлантай холбоотойгоор бусад этгээдийн өмнө үүрэг хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангууд нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдгийг үндэслэлтэйгээр магадлах нотолгоо олж авахын тулд шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл, тайлбар танилцуулгыг олж авахуйцаар аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг эдгээр стандартуудад шаарддаг. Аудит хийхдээ санхүүгийн тайлан дахь дүн, тодруулгыг нотлох нотолгоог түүврийн аргаар шалгадаг. Түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн боллого, зарчим болон ТУЗ-аар хэлэлцэн батласан үлэмж хэмжээний тооцооллыг тусгайлан шалгахад гадна санхүүгийн тайлангууд бүхэлдээ зохистой тайлагнагдсан эсэхийг үнэлдэг. Бидний хийсэн аудит нь гаргасан дүгнэлтэнд маань зохих үндэслэл болж чадна гэдэгт итгэж байна. Бид дараах зүйлсийг тайлагнаж байна:

1. Монголбанкны "Активыг ангилах ба активын эрсдлийн сан байгуулж зарцуулах журам" (шаашид "Монголбанкны журам" гэх)-д зааснаар Банк нь бүх хэвийн зээлд түүний үлдэгдлийн 1% -аар зээлийн болзошгүй алдагдлын ерөнхий сан байгуулдаг ба 2004 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон жилд 810 сая төгрөг (2003 онд 632 сая төгрөг)-ийн зардлыг Орлогын Тайланд тусгасан. Энэ нь дараах Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартуудад нийцэхгүй байна:

а) Санхүүгийн Хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт хэмээх Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 39 нь ирээдүйн болзошгүй алдагдлын санг орлогын тайланд тусгах замаар хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэхийг зөвшөөрдөггүй.

б) Банк, Санхүүгийн Байгууллагын Санхүүгийн Тайлангийн Тодруулга хэмээх Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 30 нь болзошгүй алдагдлын ерөнхий санг хуримтлагдсан ашгийн хуваарилалт байдлаар бүртгэхийг шаарддаг.

2. Банк нь чанаргүй зээлийн ангилал хийх, зээлийн алдагдлын санг байгуулахдаа дараах аргачлалыг ашигладаг:

- а) Чанаргүй зээлийг ангилахдаа зээлийн үндсэн төлбөрийн хугацаа хэтэрсэн хоногийн тоог үндэслэдэг. Зээлийн хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлтийг харгалздаггүй. Энэ нь чанаргүй зээлийн ангилал хийхдээ хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн хоногийг харгалзах ёстой гэсэн Монголбанкны журмыг зөрчиж байна.
- б) Зарим зээлийг ангилахдаа зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр хугацаандаа төлөгдөөгүй ч гэсэн зээлдэгчийн төлбөр төлөх чадварыг Банкнаас үнэлж, ангилал хийдэг. Энэ нь Монголбанкны зээлийг ангилахдаа төлбөрийн хугацаа хэтэрсэн хоногийг үндэслэнэ гэсэн мөн журмыг зөрчиж байгаа хэрэг юм.

Бид банкны 2004 оны 12-р сарын 31-нээрх нийт зээлийн 26 орчим хувийг шалгасан ба Монголбанкны журмыг мөрдөн зээлийн сан байгуулбал 125 сая төгрөгийн зээлийн болзошгүй эрсдлийн сан нэмж байгуулах шаардлагатайг тогтоосон. Энэхүү нэмэлт зардлыг санхүүгийн тайланд тусгах хэрэгтэй гэж бид үзэж байна. Хэрвээ Банк энэхүү зээлийн болзошгүй алдагдлын сангийн зардлыг нэмж бүртгэвэл Банкны тайлант жилийн 240 сая төгрөгийн цэвэр ашиг 125 сая төгрөгөөр буурч 115 сая төгрөг болох юм. Үүнтэй холбоотойгоор эздийн өмч 9,238 сая төгрөг болж буурна. Бидний шалгаагүй зээлийн хувьд Монголбанкны журмыг мөрдөн сан байгуулбал хэдий хэмжээний зээлийн болзошгүй эрсдлийн сан нэмж байгуулах шаардлагатайг магадлан тогтоох боломжгүй байв.

Бид, дээр дурдсан асуудлуудын нөлөөллөөс бусад зүйлсийн хувьд 4-өөс 28-р хуудсанд нийтлэгдсэн санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг үзүүлэлтийнхээ хувьд Анод банкны 2004 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон оны үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

КПМГ

Улаанбаатар, Монгол Улс
2005 оны 3 сарын 30



KPMG, a partnership established under the Malaysian law, is the Malaysian member firm of KPMG International, a Swiss cooperative.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

АКТИВ	2004 мян.төг
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	13 616 514
Банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж	3 909 800
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	12 817 014
Зээл ба урьдчилгаа	94 330 529
Бусад актив	5 546 032
Үндсэн хөрөнгө	3 712 639
НИЙТ АКТИВ	133 932 528

ПАССИВ	
Харилцагчдын харилцах, хадгаламж	111 892 524
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	2 443 896
Татварын өглөг	111 655
Бусад пассив	8 117 814
Хоёрдогч өглөг	2 004 027
НИЙТ ПАССИВ	124 569 916

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Дүрмийн сан	9 004 182
Хуримтлагдсан ашиг	358 430
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9 362 612

НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	133 932 528
--------------------------------------	--------------------

**2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР
БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

	2004 мян.төг
Хүүгийн орлого	24 270 383
Хүүгийн зардал	(14 267 665)
Хүүгийн цэвэр орлого	10 002 718
Хүүгийн бус орлого	1 287 717
Үйл ажиллагааны ашиг	11 290 435
Үйл ажиллагааны зардал	(4 832 855)
Болзошгүй эрсдийн сангууд	(5 726 375)
Татварын өмнөх ашиг	731 205
Татвар	(372 775)
Тайланг жилийн цэвэр ашиг	358 430
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	(117 999)
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсны дараах цэвэр ашиг	240 431

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

(Мянган төгрөг)

	FY 2003	FY 2004	Өөрчлөлт
Нийт актив	94 145 050	133 932 528	42,3%
Нийт пассив	87 522 869	124 569 916	42,3%
Нийт зээл	66 781 004	94 330 529	41,3%
Нийт өөрийн хөрөнгө	6 622 181	9 362 612	41,4%
Эрсдлийн сангийн өмнөх орлого	2 494 884	6 007 580	140,8%
Цэвэр ашиг	354 170	240 431	-32,1%
Өөрийн хөрөнгийн			
хүрэлцээний үзүүлэлт	10,31%	10,45%	1,4%
Активын өгөөж	0,38%	0,18%	-52%
Өөрийн хөрөнгийн өгөөж	5,35%	2,57%	-52%
Цэвэр хүүгийн марж	4,84%	7,47%	54,4%



ПАССИВ

/Мянган төгрөгөөр/

ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

	2003	2004	Өөрчлөлт	Өөрчлөлт (%)
Харилцагчдаас татсан хөрөнгө	81 527 437	111 892 524	30 365 087	37,25%
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	735 233	2 443 896	1 708 663	232,40%
Татварын өглөг	145 467	111 655	-33 812	-23,24%
Бусад пассив	4 177 264	8 117 814	3 940 550	94,33%
Хоёрдогч өглөг	937 468	2 004 027	1 066 559	113,77%
Нийт пассив	87 522 869	124 569 916	37 047 047	42,33%
Дүрмийн сан	6 000 075	9 004 182	3 004 107	50,07%
Хуримтлагдсан ашиг	622 106	358 430	-263 676	-42,38%
Нийт өөрийн хөрөнгө	6 622 181	9 362 612	2 740 431	41,38%
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	94 145 050	133 932 528	39 787 478	42,26%

ТАЙЛБАР

2004 онд Анод банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны үзүүлэлтээс 37 тэрбум төгрөг буюу 42.3 хувиар өссөн байна. Уг өөрчлөлтийг бүтцээр нь авч үзвэл харилцах ба хадгаламжийн хэмжээ 30.3 тэрбум төгрөг буюу 37.25 хувиар, банкуудаас татсан эх үүсвэр 1.7 тэрбум төгрөг буюу 232.4 хувиар, хоёрдогч өглөг 1 тэрбум төгрөг буюу 113 хувиар тус тус нэмэгдсэн байна. Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцох журмын дагуу хоёрдогч өглөг нь 2-р зэргийн өөрийн хөрөнгөд ордог. Хоёрдогч өглөгийн өсөлтийг хасч нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийг тооцвол 41.1 хувь болж, өмнөх онд 42.3 хувь байснаас буурч байгаа нь энэ онд дүрмийн сан ба хуримтлагдсан ашгийн өсөлт татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс давж гарсныг илэрхийлнэ.

Хадгаламжийн нэрлэсэн хүүг 2004 онд хоёр удаа өөрчлөн бууруулсан ч Анод банкны хадгаламжийн хэмжээ тогтвортой өсч байгаа нь харилцагч, хадгаламж эзэмшигчдийн дунд Анод банкны нэр хүнд өндөр, үзүүлж буй үйлчилгээний чанартай байгааг харуулж байна.

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөгөөр/

	2003	2004	Өөрчлөлт	Өөрчлөлт(%)
<i>Хүүгийн орлого</i>	11 896 682	24 270 383	12 373 701	104%
<i>Хүүгийн зардал</i>	(7 343 548)	(14 267 665)	-6 924 117	94%
Цэвэр хүүгийн орлого	4 553 134	10 002 718	5 449 584	120%
Хүүгийн бус орлого	444 810	1 287 717	842 907	189%
Үйл ажиллагааны орлого	4 997 944	11 290 435	6 292 491	126%
Үйл ажиллагааны зардал	(2 503 060)	(4 832 855)	-2 329 795	93%
Болзошгүй эрсдлийн сангууд	(1 633 538)	(5 726 375)	-4 092 837	251%
Татварын өмнөх ашиг	861 346	731 205	-130 141	-15%
Татвар	(468 010)	(372 775)	95 235	-20%
Татварын дараах ашиг	393 336	358 430	-34 906	-9%
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	(39 166)	(117 999)	-78 833	201%
Тухай жилийн ашиг	354 170	240 431	-113 739	-32%
Хүүгийн бус орлого	444 810	1 287 717	842 907	189%
Цэвэр шимтгэлийн орлого	188 840	518 070	329 230	174%
Арилжааны цэвэр орлого	202 015	842 892	640 877	317%
Ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал	-30 479	-131 014	-100 535	-330%
Бусад үйл ажиллагааны орлого	84 434	57 769	-26 665	-32%
Хүүгийн бус орлого	444 810	1 287 717	842 907	189%

ТАЙЛБАР

2004 онд Анод банкны цэвэр хүүгийн орлого өмнөх жилийнхээс 120 хувиар өсч 5.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад үйл ажиллагааны зардал 2.3 тэрбум төгрөгөөр, болзошгүй эрсдлийн сангийн зардал 4 тэрбум төгрөгөөр өсч татварын дараах цэвэр ашиг 240.4 сая төгрөг байсан.

Хүүгийн бус орлогын хэмжээ 2004 онд өмнөх онтой харьцуулахад 2.9 дахин нэмэгдэж 1.28 тэрбум төгрөгт хүрэхэд валютын арилжааны цэвэр ашиг 4 дахин буюу 403 сая төгрөгөөр, алт арилжааны цэвэр ашиг 4.6 дахин буюу 238 сая төгрөгөөр өссөн нь голчлон нөлөөлсөн байна.

2004 онд Анод банкны үйл ажиллагааны зардал 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүний 1.2 тэрбум төгрөг нь боловсон хүчинтэй холбоотой үйл ажиллагааны зардлын өсөлт юм. Энэхүү өсөлт нь 2004 онд банкны нийт боловсон хүчний тоо 164 хүнээр нэмэгдэж, улмаар цалингийн фонд 2 дахин өссөнтэй холбоотой.

Актив	2003	2004	Өөрчлөлт	Өөрчлөлт(%)
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	12 115 898	13 616 514	1 500 616	12%
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	1 500 000	3 909 800	2 409 800	161%
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	9 105 664	12 817 014	3 711 350	41%
Зээл ба урьдчилгаа	66 781 004	94 330 529	27 549 525	41%
Бусад актив	1 696 792	5 546 032	3 849 240	227%
Үндсэн хөрөнгө	2 945 692	3 712 639	766 947	26%
Нийт актив	94 145 050	133 932 528	39 787 478	42%

Зээл ба урьдчилгаа	2003	2004	Өөрчлөлт
Улсын байгууллагын	819 792	36 115	-95,59%
Хувийн хэвшлийн	45 193 361	65 717 760	45,41%
Гадаадын байгууллагын	7 690 492	10 223 495	32,94%
Төрийн бус байгууллагын	61 817	110 000	77,94%
Иргэдийн	14 668 692	25 280 500	72,34%
Цалингийн зээл	12 012	348 509	2801,34%
Нийт зээл ба урьдчилгаа	68 446 166,00	101 716 379,00	48,61%

Зээл ба урьдчилгаа	2003	2004	Өөрчлөлт
Хөдөө аж ахуй	1 549 674	2 839 017	83,20%
Эрчим хүч, усан хангамж	3 057 433	2 717 962	-11,10%
Барилга	6 631 164	12 301 794	85,51%
Уул уурхай, олборлох салбар	10 491 398	21 564 977	105,55%
Аж үйлдвэр	8 670 598	10 562 421	21,82%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	26 987 369	33 473 128	24,03%
Зочид буудал, ресторан	1 228 647	1 600 894	30,30%
Тээвэр	2 733 883	4 899 596	79,22%
Үл хөдлөх хөрөнгө	1 945 050	7 053 867	262,66%
Эрүүл мэнд, боловсрол	425 576	892 698	109,76%
Санхүүгийн зуучлал	387 828	576 952	48,76%
Бусад	4 337 546	3 233 073	-25,46%
Нийт зээл ба урьдчилгаа	68 446 166,00	101 716 379,00	48,61%

Зээлийн төрөл	2003	2004	Өөрчлөлт
Хэвийн зээл	63 184 624	81 025 123	28,24%
Хугацаа хэтэрсэн	3 609 743	10 395 194	187,98%
Чанаргүй зээл	1 651 799	10 296 062	523,32%
Хэвийн бус	1 235 633	6 010 723	386,45%
Эргэлзээтэй	135 779	2 535 155	1767,11%
Найдваргүй	280 386	1 750 183	524,21%
Нийт зээл ба урьдчилгаа	68 446 166	101 716 379	48,61%

ТАЙЛБАР

АКТИВ БА ЗЭЭЛ

АКТИВ

Анод банкны нийт активын хэмжээ 2004 онд өмнөх оноос 39.8 тэрбум төгрөг буюу 42 хувиар өсч 133.9 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт активын өсөлтөнд зээл ба урьдчилгаа 27.5 тэрбум төгрөг буюу 41 хувиар, үнэт цаас 3.7 тэрбум төгрөг буюу 41 хувиар, бусад банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж 2.4 тэрбум төгрөг буюу 161 хувиар өссөн нь голчлон нөлөөлсөн.

ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

Зээлийн өрийн үлдэгдлийг харилцагчдаар нь авч үзвэл: 2004 онд төрийн өмчийн үйлдвэрийн газруудад олгосон зээл буурч, хувийн секторт олгосон зээлийн үлдэгдэл 20.5 тэрбум төгрөг буюу 45 хувиар, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 10.6 тэрбум төгрөг буюу 72.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зээлийн үлдэгдлийн өсөлтийг салбарын хувьд харвал: барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл 5.6 тэрбум төгрөг буюу 85.5 хувиар, уул уурхай ба олборлох үйлдвэрт олгосон зээлийн үлдэгдэл 11 тэрбум төгрөг буюу 105 хувиар, бөөний болон жижиглэнгийн худалдаанд олгосон зээлийн үлдэгдэл 6.5 тэрбум төгрөг буюу 24 хувиар тус тус өсчээ.

Нийгмийн Арга хэмжээ

ХҮҮХДҮҮД МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭНД БҮТЭН ОДОР ҮНЭГҮЙ ТОГЛОЛОО

Анод банк байгуулагдсаны 5 жилийнхээ ойг тохиолдуулан Монголын Үндэсний соёл, амралтын хүрээлэнд нийт харилцагч, ажиллагсдын хүүхдүүдийг оролцуулсан цогц арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд оролцогчид олон төрлийн хөгжилтэй уралдаан тэмцээнд оролцох, шагнал авах, тоглоомууд дээр тоглох, нэртэй хамтлаг дуучид, хошин шогийн тоглоолтыг амьдаар үзэх, өөрсдийн хүндэлдэг хамтлаг дуучидтай зургаа авахуулан сэтгэл хангалуун нэг өдрийг өнгөрүүлсэн юм. Мөн нисдэг тэргээр Улаанбаатар хот дээгүүр нисч, ойн баярын бэлэг болох чихэр тоглоом гэх мэт зүйлсийг нисдэг тэргээс тараасан нь маш өвөрмөц арга хэмжээ байлаа. Зарим азтай оролцогчид нь Анод банкны Цахим төгрөг карт, хадгаламжийн дэвтэр эзэмшигчид болж байлаа.

ШИЛДЭГ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Үүсэн байгуулагдсанаа 5 жилийн ойг угтсан арга хэмжээний нэг “Шилдэг Эрдэм Шинжилгээний Ажил”-ын уралдааныг оюуны бүтээлийг үнэлэх, оюуны хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготойгоор Анод банк зарлан амжилттай зохион байгуулсан, үр өгөөж сайтай арга хэмжээ боллоо. Уралдаанд оюутан залуус, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагын ажиллагсад, шинжлэх ухааны байгууллагад ажиллагсад амжилттай оролцсон бөгөөд уралдаанд ирсэн бүтээлүүд дараах сэдэвтэй байлаа:

- Арилжааны банкуудын өрсөлдөх чадвар, түүнийг тодорхойлох хүчин зүйлцүүд
- Хөрөнгийн болон цнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд банкуудын цэрэг оролцоо
- Зээлдэгчийн рейтинг, Монголын нөхцөлд тооцох аргачлал
- Монголын зах зээлд гадаадын банкуудын ажиллах боломж

Дээрх сэдвүүдээр бичигдсэн илтгэлүүд нь банкинд нэвтрүүлж болохуйц шинэлэг санаа бүхий оюуны бүтээлүүд байсан юм.

ЗУСЛАНГУУДЫН ХОГИЙГ ЦЭВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ойн арга хэмжээний хүрээнд хотынхоо орчин тойрныг цэвэрхэн байлгах зорилготойгоор зуслангуудын хогийг цэвэрлэх ажлыг санаачлан, ивээн тэтгэж, амжилттай зохион байгуулсан. Зуслангийн оршин суугчид болон хотын тохижилт, үйлчилгээний компанийнхан уг ажлыг маш халуун дулаанаар хүлээн авч дэмжиж, талархаж байсан.

